

Үйл ажиллагаа 1.

Бурханы хуулиудад дуулгавартай байх

- Таны амьдарч буй газарт ямар ямар хууль тогтоомж байдаг вэ?
- Эдгээр хуулийг байнга дагаж мөрдөх эсвэл мөрдөхгүй байх нь ямар үр дүнд хүргэх вэ?
- Энэ харьцуулалт нь Бурханы хуулиудтай юугаараа төстэй эсвэл ялгаатай вэ?

Нифай болон түүний дагагчид Их Эзэний тушаалуудыг дагасан (2 Нифай 5:10-ыг үзнэ үү). Төгс эзэмших сургаалын судрын хэсгийн Мозая 2:41-ийг уншаад, Хаан Бенжамин Бурханы зарлигуудыг сахих талаар хүмүүст юу ойлгуулахыг хүссэнийг олж мэд. Та магадгүй энэ эш татсан эшлэлийг 2 Нифай 5:10-тай холбож болох юм.

- Бурханы хуулиудыг дуулгавартай дагах нь биднийг аз жаргалтай байхад хэрхэн тусалдаг гэж та бодож байна вэ?
- Есүс Христ дуулгавартай байдлын жишээг хэрхэн харуулсан бэ?
- Бурханы ямар тушаал танд илүү их аз жаргал авчирдаг вэ?

Үйл ажиллагаа 2.

Ажил хөдөлмөр ба бие даах чадвар

Цаасан дээр эсвэл судлах тэмдэглэл дээрээ шаргуу хөдөлмөрөөс гарах үр өгөөжийн жагсаалт бичихэд багахан хугацаа зарцуул.

2 Нифай 5:11, 15, 17-г уншаад нифайчуудын ажилласан янз бүрийн арга зам, тэдний хөдөлмөрийн үр дүнг тодорхойл.

Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө товхимол (2011) дахь “Ажил хөдөлмөр ба бие даах чадвар”-ыг уншиж, ажил хөдөлмөрийн зарчмын талаар юу сурч мэдсэнээ хар.